

**ТАНИЛЦУУЛГА**  
**2024 ОНЫ 01 ДҮГЭЭР УЛИРАЛД ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР,**  
**НЭГДСЭН ЭМНЭЛЭГТ ХАНДАЖ ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН**  
**ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТУХАЙ**

2024 оны 03 дугаар 20

Мандалговь

Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэгт хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын бүртгэл, шийдвэрлэлт, хариу өгөлт, тайланд гүйцэтгэлийг сайжруулахад анхаарч ажиллаж байна. 2024 оны 01 дүгээр улиралд иргэдээс биеэр болон бичгээр нийт 12 өргөдөл, гомдол, хүсэлтийг ирсэнээс 9 өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэж 100%-ийн гүйцэтгэлтэй, хугацаа хоцорч шийдвэрлэсэн 0, судлагдах шатандаа явж байгаа 3 хүсэлт байна.

Өргөдөл гомдлын шийдвэрлэсэн дундаж хугацаа 21 хоног байна.

**Нийт ирүүлсэн 12 өргөдлийг бүтэц, хэлбэрээр нь авч үзвэл:**

**Хэлбэрээр:**

Бичгээр 12

**Бүтцээр:**

- Хүсэлт -11 буюу 91,7%
- Гомдол - 1 буюу 8,3% тус тус эзэлж байна.

**Өргөдөл гомдол санал хүсэлтийг агуулгаар нь ангилж үзвэл:**

- Ажилд орохыг хүссэн-10
- Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой-1
- Хөдөлмөрийн харилцаатай холбоотой буюу ажлын зохицуулалт хийлгэх тухай-1

**Гомдол хүсэлтийг шийдвэрлэсэн байдал**

- Өлзийт сумын ЭМТ-тэй холбоотой гомдлын дагуу тус суманд очиж ажиллан эмнэлгийн үйл ажиллагаатай танилцаж Эмнэлгийн тусламж үйлчилгээний дутагдал, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн зөрчил байна гэж үзэж холбогдох эмч, мэргэжилтнүүдэд хариуцлага тооцож, хариу мэдэгдэх саналыг сумын Засаг дарга болон Эрүүл мэндийн төвийн дарга нарт албан бичгээр хүргүүлсэн тухай дурдсан албан бичгийг гомдол гаргагч нарт хүргүүлэн шийдвэрлэж ажиллалаа.
- Нэгдсэн эмнэлгийн сул ажлын байрны зарын дагуу иргэдээс ирүүлсэн 10 хүсэлтийг судлан бүртгэж хариуг журмын дагуу шийдвэрлэж холбогдох эздэд хүргэлээ
- Үүнд: Их эмч-2, хүний нөөцийн албаны дарга -1, лабораторийн техникч-1, үйлчлэгч-4, туслах сувилагч-2-аар ажилд орохыг хүссэн нийт 10 иргэнээс 6 хүнийг ажлын байранд авч ажиллуулан өргөдлийг шийдвэрлэсэн. Хүний нөөцийн албаны дарга, туслах сувилагч 3 иргэний өргөдлийг судлан шийдвэрлэх шатандаа явж байна.



- Нэгдсэн эмнэлгийн даргын албан үүргийг дангаар гүйцэтгэх тухай хүсэлтийг хүлээн авч НЭ-ийн даргын албан үүргийг дангаар гүйцэтгэх хуулийн заалтыг үндэслэн тушаал гаргахыг Хүний нөөцийн төлөвлөлт, сургалт, мэргэжлийн зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэнд үүрэг өгсний дагуу төрийн үйлчилгээний удирдах ажилтан тул томилохоос өмнө Авилгатай тэмцэх газраас дүгнэлт ирсэн тохиолдолд томилох тушаал гаргах талаар хүсэлт гаргагчид утсаар мэдэгдлээ.

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:

ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Г.ЦЭРЭННАДМИД



ХЯНАСАН:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА



Б.АЛТАНТӨГС





2024 оны 01 дүгээр улирлын байдлаар

2024 оны 03 дугаар сарын 19

Байгууллагын нэр	Өргөдөл гомдлын төрөл				Хүлээн авсан хэлбэр				
	Мэдэгдэл	Гомдол	Санал	Хүсэлт	Биеэр	Утсаар	Цахимаар	11-11 төвөөс шилжүүлсэн	Албан бичгээр
	1	2		3	4				5
Тайлбар:	Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид заасан хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбогдон иргэдээс гарсан хүсэлт	Төрийн байгууллага албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсэн гэж үзэж сэргээлгэхээр гаргасан хүсэлт	Төрийн ба нутгийн удирдлагын байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулах, шинэчлэх талаар гаргасан иргэний хүсэлтийг	Байгууллагын дотоод асуудал, үйлчилгээ авах хүсэлтээс бусад	Иргэн өөрийн биеэр ирж, өргөдөл өгсөн	Байгууллагын тусгай дугаараар	Вэб сайт, аппликэйшн, сошиал флатформ, мэйл г.м	11-11 төвд бүртгэгдэн, цахимаар шилжүүлэн	ААНБ, хуулийн этгээдээс албан бичгээр ирүүлсэн
Эрүүл мэндийн газар		1		1	2				
Нэгдсэн эмнэлэг				10	10				
<b>Нийт</b>		<b>1</b>		<b>11</b>	<b>12</b>				





Гомдлын агуулга	Тоо	Хувь	Өргөдөл гомдлыг бууруулахад цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал
Өлзийт сумын Эрүүл мэндийн төвийн эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой гомдол	1	100%	Эмнэлгийн үйл ажиллагаатай танилцаж Эмнэлгийн тусламж үйлчилгээний дутагдал, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн зөрчил байгаа учраас цаашид эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулахад анхаарч ажиллах хэрэгтэй.



2024 оны 1 дүгээр улирлын байдлаар

2024 оны 03 дугаар сарын 19

	Шийдвэрлэлтийн байдал									
	Шийдвэрлэж хариу өгсөн				Бусад байгууллагад шилжүүлсэн		Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн /30 хоног/	Сунгалт хийсэн боловч хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн /60 хоног/	Хугацаа болоогүй	Шийдвэрлэх боломжгүй
	Албан бичгээр	Цахимаар	Утсаар	Биечлэн	Харьяаллын дагуу шилжүүлсэн тоо	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн				
Эрүүл мэндийн газар	1		1							
Нэгдсэн эмнэлэг					7					3
<b>Нийт</b>	<b>1</b>		<b>1</b>		<b>7</b>					<b>3</b>

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН: ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН   
 ХЯНАСАН: ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА  БАЛТАНТӨГС



Г.ЦЭРЭННАДМИД